

**БАЯНБУЛАГИЙН ТУУРИЙН ЭРТНИЙ ХҮНИЙ ОЛДВОРЫН
ПАЛЕОПАТАЛОГИЙН СУДАЛГААНЫ ДҮНГЭЭС**

Э.Мижиддорж
/Улаанбаатарын их сургууль/

Өмнөговь аймгийн Номгон сумын нутагт орших Баянбулагийн туурь нь Монголын эртний хот суурины чухал дурсгалын нэг бөгөөд судлаачдын анхаарлыг зүй ёсоор татсаар иржээ¹.

2009 онд Монгол-Оросын хамтарсан “Төв Азийн археологийн шинжилгээ” төслийн баг тус тууриас булшны тодорхой зохион байгуулалт болон зүй тогтолгүй булагдсан 14 хүний араг ясыг илрүүлэн малтав.

Уг олдвор нь манай орны Хүннүгийн үеийн хот сууринаас олдож байгаа бүлэг хүний оршуулгын анхны тохиолдол болж байгаагаараа онцлог болно /хавсралт 1, 2/.

Бид эдгээр олдворыг Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхимийн дэргэдэх “Археологийн лаборатори”-д цэвэрлэн биоархеологийн цогц судалгаа (гавал судлал, хэмжилтийн бус шинж, өвчлөл судлал г.м.) хийж зарим үр дүнд хүрсэн юм.

Энэхүү илтгэлд Баянбулагийн туурийн эртний хүний олдворт палеопаталогийн (эртний өвчлөл судлал) судалгаа хийх замаар эдгээр хүмүүсийн амьдралын хэв маяг, хоол хүнс, эрхлэж байсан аж ахуйг тодруулахыг хичээсэн юм. Палеопаталогийн судалгаа нь эртний нүүдэлчдийн хоол хүнс, эрүүл мэндийн байдал зэргийг тодруулах хүн судлалын орчин үеийн судалгааны арга болно.

Бидний хийсэн судалгаагаар Баянбулагийн тууриас олдсон эртний хүний олдворуудад толгойн ясны гэмтэл бэртэл, шүдний янз бүрийн өвчлөл /шүдний цоорол, шүдний буглаа, шүд сулрах, шүд унах, эрүү шүдний гаж хөгжил, шүдний буруу ургалт г.м./, амны хөндий өвчлөлт түгээмэл ажиглагдсан.

Олдворуудад тохиолдож буй өвчлөлтийн шинж тэмдэг, түүнд нөлөөлсөн хүчин зүйл, судалгаанаас гарсан үр дүнг тодруулан үзье.

Толгойн ясны гэмтэл, бэртэл

Палеопаталогийн судалгаагаар эртний хүний олдворын толгойн ясанд амьд байх үед нь үүссэн цууралт, хагаралт, зүсэгдсэн, цохигдсон зэрэг гэмтлийг ажиглалтын аргаар олдворын тодорхойлж болдог. Судалгаанд хамруулсан нийт 14 олдворын 4-д нь бэртэл гэмтэлийн шинж тэмдэг илэрсэн юм. Үүнд:

1. СК 3-р олдвор (ахимаг насны эрэгтэй). Зүүн хөмсөгний төвгөр дээр амьд байх үед үзүүртэй мэсэнд зүсэгдсэн сорвитой. Зүсэлтийн урт 1.7 см байна.

¹ Х.Пэрлээ. Монгол ард улсын эрт дундад үеийн хот суурины товчоон. УБ., 1961; Д.Цэвээндорж, З.Батсайхан, Ц.Төрбат. Сүннүгийн хот суурины судалгаа. // ШУА-ийн мэдээ. УБ., 1994; З.Батсайхан. Хүннү. УБ., 2002; Д.Цэвээндорж, Д.Баяр, У.Эрдэнэбат. Монголын эртний хот суурины судалгаа. - Монгол улсын шинжлэх ухаан. Боть 32. УБ., 2007; Д.Эрдэнэбаатар, Т.Идэрхангай, Э.Мижиддорж, А.В. Харинский, А.М.Коростелев, Д.Е.Кичигин, С.С.Матренин, И.Ю.Гребнников, А.В.Варенов, А.А.Ковалев. Монгол-Оросын хамтарсан “Төв Азийн археологийн шинжилгээ” археологийн хээрийн шинжилгээний ангийн Хөвсгөл аймгийн Ханх сум, Өмнөговь аймгийн Номгон сумдын нутагт ажилласан археологийн судалгааны ажлын 2009 оны тайлан. УБ-ИС-ийн НУФ-ийн Археологийн тэнхимийн ГБС. УБ., 2009.

2. СК 7-р олдвор (залуу эрэгтэй). Зүүн хөмсөгний төвгөр дээр мэсээр зүсэгдэн эдгэсэн ул мөртэй. Зүсэлтийн урт 2 см байна.

3. СК 1-р олдвор (залуу эрэгтэй). Духны ясан дээр баруун хөмсөгний төвгөрт цохигдсон ул мөртэй.


4. СК 18-р олдвор (идэр насны эрэгтэй). Духны ясан дээр баруун хөмсөгний төвгөрт гэмтлийн ул мөртэй.

Дээрх гэмтэл, бэртлүүд нь тухайн нас барагчдыг амьд байх үед тохиолдсон болох нь ясны эдгэрэлтээс харагдаж байна. Мөн эдгээр гэмтлүүд зөвхөн нүүрэн тус газар, духны хэсэгт тохиож байгаа нь зориудаар үйлдэгдсэн хэмээн таамаглаж болохоор байна.

Шүдний өвчлөлүүд

Шүдний цоорол. Баянбулагийн туурийн хүний олдворын шүдний цоорол өвчний тархалтыг хүн бүрт шүд тус бүрээр нь авч үзсэн. Судалгааны үр дүнгээс үзэхэд Баянбулагийн туурийн хүн амд шүд цоорох өвчин нэлээд түгээмэл байсан юм. Судалгаанд хамруулсан 14 хүний олдворын хоёроос бусдад нь шүд нь цоорсон, ингэхдээ ихэнх тохиолдолд шүдний цооролт дунд болон хүнд шатанд хүртэл явагджээ.

Цооролт нь ихэвчлэн бага араа, их араанд тохиолдож байгаа /зураг №1/ ба соёо болон үүдэн шүднүүдэд цооролт огт ажиглагдсангүй. Энэ нь тухайн шүднүүдийн үүрэгтэй холбоотой.



Шүдний өвчлөлтийг насны хувьд авч үзвэл мэдэгдэхүйц ялгаа ажиглагдахгүй байгаа ч нас ахих тусам цоорхой шүдний тоо нэмэгдэх, цоорлын хөндийн хэмжээ ихсэх хандлагатай байв.

Эртний нүүдэлчдийн дунд шүдний цоорлын судалгаа цөөн тоогоор хийгдсэн байдаг. Хүрлийн сүүлч, төмрийн эхэн үеийн Чандманий соёлын олдворуудад Б.Нарангийн хийсэн судалгаагаар 108 хүнд 3 тохиолдол нэг хүүхэд, насанд хүрсэн хоёр эмэгтэй хүнд² илэрсэн ба шүдний цоорлууд нь их араанууд М1, М2, М3 дээр тохиолдсон байна. Мөн Монголын төв нутгаас олдсон хүннүгийн үеийн эртний нүүдэлчдийн олдворт шүдний өвчлөлийн судалгаа хийхэд, 45 хүнээс 12 хүнд

буюу 26.6%-д нь нэгдүгээр үүдэн шүдэнд 1, соёонд 1, бага араанд байхгүй, их араанд 12 цоорол ажиглагдсан ба эрэгтэй хүнд - 14, эмэгтэй хүнд - 4 тохиолдол гарсан байна.

Шүдний цооролтод хамгийн их нөлөөлдөг хүчин зүйл бол хүнс тэжээл юм. Судлаачдын үзэж байгаагаар шүдний цооролт нь түүхэн эрин үе наашлах тусам ихсэж байгаа бөгөөд хотжилтын үйл явцтай нягт холбоотой байдаг ажээ. Өөрөөр хэлбэл, шүдний цоорол нь суурьшмал иргэдэд харьцангуй их байдаг байна.

² Б.Наран. Баруун Монголын эртний нүүдэлчдийн өвчлөлт. УБ., 2003.т. 44

I МОНГОЛЫН ЭРТНИЙ ТҮҮХИЙН АСУУДАЛ

Шүдний буглаа. Судалгаанд хамруулсан нийт 14 олдворын 5-д нь шүдний буглаа өвчний шинж тэмдэг ажиглагдаж байна. Үүнд:

- СК 3 Maturus эрэгтэйн баруун дээд талын M1, M2,
- ФР-24 Juvenilis эрэгтэйн дээд зүүн талын C,
- СК 10-р олдвор буюу Adultus эрэгтэйн эрүүний зүүн M1
- СК 18 Adultus эрэгтэйн зүүн дээд талын M2
- СК 8-р олдвор буюу Maturus эрэгтэйн доод баруун M1, M2, M3, P2 шүднүүд болно.

Эдгээр хүмүүсийн хувьд шүдний буглаа нь ихэвчлэн шүдний цоорол үүсгэсэн байгаа ба цоорлын хүнд шат (3 балл) -нд орсон байна /Зураг №2/.



Шүд сүлрах (Парадонтоз). Судалгаанд хамруулсан нийт 14 олдворын 6 нь парадонтозын өвчлөлтэй илэрсэн юм. Үүнд,

- СК 3-р олдвор буюу Maturus эрэгтэйн дээд баруун I1, I2, зүүн P1, M1, M2 шүд
- СК 10-р олдвор буюу Adultus эрэгтэйн эрүүний үүдэн I1, I1, C шүднүүд
- ФР 24-р олдвор буюу Juvenilis эрэгтэйн үүдэн I1, I1 шүд
- СК 8-р олдвор буюу Maturus эрэгтэйн зүүн дээд C шүд
- СК 17 олдвор буюу Maturus эрэгтэйн дээд баруун талын M1, C, үүдэн I1, I1 шүд, зүүн талын C, доод талын баруун C, үүдэн I1, I1 шүд, зүүн талын C,
- СК 12 олдвор буюу Adultus эрэгтэйн баруун дээд M1, C

Парадонтозын өвчлөлтэй эдгээр олдворууд нь насны хувьд залуу буюу идэр насныхан байна. Өвчлөлтийн хувьд ихэвчлэн үүдэн болон соёо шүд ажээ.

Амьд байх үеийн шүд унах. Судалгаанд хамрагдсан Баянбулагийн олдворуудад шүдний уналт төдий л элбэг биш 14 хүнээс 1 тохиолдол илэрсэн юм. СК-8 буюу 35-50 Maturus насны эрэгтэй хүний эрүүний зүүн талын их 2, 3-р араа /M2, M3/ амьдад унаж яс нь битүүрэн эдгэсэн байв.

Энэ хүний араа шүднүүд бүгд цоорсон, хүнд шатанд орсон байснаас үзвэл дээрх унасан шүднүүд цоорох өвчнөөр өвчилж байгаад унасан бололтой.

Шүдний гэмтэл. Энэ хэсэгт бид шүдний элэгдэл, шүдний эмтрэл зэргийг авч үзсэн юм. Судалгаагаар Баянбулагийн олдворуудад дээрх хоёр өвчлөл аль аль нь тохиолдсон болно. Бидний судалгаанд хамруулсан Баянбулагийн нийт олдвороос 6-д нь шүдний элэгдлийн шинж тэмдэг илэрсэн юм. Үүнд,

- СК 1 Juvenilis эрэгтэй, СК 8 Maturus эрэгтэй, СК 17 Adult эрэгтэй, СК 3 Maturus эрэгтэй, ФР 32 Maturus эрэгтэй, СК 18 Juvenilis эрэгтэй зэрэг болно.

Энэ нь эдгээр хүмүүст шүдний элэгдэлт багагүй байсныг харуулж байна. Үүнээс 20-25 насны залуу хүний шүдэнд элэгдэлт ажиглагдаж байгаа нь сонирхолтой юм.

Үүнээс гадна дээрх 14 хүний үүдэн болон араа шүднүүдэд хүнс тэжээлийн дутагдал болох паалангийн хэрчлээс ихэнхэд нь мэдэгдэж байсан юм.

Эрүү шүдний янз бүрийн гажиг. Бид Баянбулагийн тууриас олдсон эдгээр 14 олдворт дээрх өвчлөлүүдээс гадна эрүү шүдний янз бүрийн гаж хөгжил байгаа эсэхийг ажиглалтын аргаар тодруулан үзсэн болно. Үүнд,

Шүдний буруу ургалт. Баянбулагийн тууриас олдсон дээрхи нийт 14 хүний олдворын 4 т нь буруу ургалт ажиглагдав юм. Үүнд:

- СК 10 Juvenilis эрэгтэйн доод үүдэн хоёр шүд жижгэрэн, хөндлөн болсон байдалтай, баруун дээд талын М3 гажиг хөгжилтэй
- СК 19 Adultus эрэгтэйн баруун доод М3 гажиг хөгжилтэй
- ФР-24 Juvenilis эрэгтэйн дээд үүдэн шүдний ар, тагнайн хэсэгт илүү шүд цухуйсан байна.
- СК 9 Juvenilis эрэгтэйн М3-ууд буюу их араанууд ургалтын гажигтай байна. Энэ араанууд төвгөрөөрөө М2-луу шахсан байдалтай.

Олдворуудад ажиглагдсан амны хөндийн өвчлөлийн тохиолдлуудыг нэгтгэн хүснэгтээр үзүүлбэл,

Хүснэгт 2. Амны хөндийн өвчлөлт

	Олдвор	Нас	Шүдний цоорол	Уналт	Буглаа	Буруу ургалт	Шүдний гэмтэл	Парадонтоз-шүд сулрах
1	СК 13	Adult	2					
2	СК5	Adult	2					
3	СК 3	Matur	4		6			
4	СК 19	Adult	3			М3	элэгдэл	1
5	СК 10	Adult	2		1	II, II, М3		3
6	ФР 24	Juve				Тагнайд		3
7	СК 18	Adult	2		1			1
8	СК 17	Matur	1				элэгдэл	9
9	СК 12	Adult	1		2			
10	СК 8	Matur	10	2	4			3
11	СК 1	Juve	1					
12	СК 7	Juve	5					
13	СК 9	Adult	2		1	М3-үүд		
14	ФР 32	Matur	2					

I МОНГОЛЫН ЭРТНИЙ ТҮҮХИЙН АСУУДАЛ

Бүгд	37	2	15	6	4	20
------	----	---	----	---	---	----

Хүснэгтэд өгөгдсөн тоон үзүүлэлтээс харахад эдгээр хүмүүст шүдний янз бүрийн өвчлөлт ихээхэн давтамжтай байсан нь ажиглагдсан болно.

Төгсгөл

Баянбулагийн туурийн эртний хүний олдворын палеопаталогийн судалгааны үр дүнгээс үзэхэд тухайн хүмүүсийн дунд төмөр дутагдлын өвчин огт тохиолдоогүй ба харин гэмтэл бэртэл, шүд болон амны хөндийн өвчлөл нилээд их байсан ба үүнээс шүдний цоорол, шүдний буглаа, шүд сулрах зэрэг өвчин харьцангуй их илэрсэн ба зарим тохиолдолд маш хүнд хэлбэрийн шинж тэмдэг ажиглагдав. Харин шүд чулуужих, амьдад шүд унах явдал бага байна.

Гэмтэл бэртэлийн 4 тохиолдол илэрсэн бөгөөд ихэвчлэн гавлын ясны нүүрний хэсгийн дээд талд тохиолдож байгаа нь гадны хүчин зүйлийн улмаас зориудаар үйлдэгдсэн буюу тухайн хүмүүсийн эрхлэх ажил, үүрэгтэй ямар нэгэн байдлаар холбоотой бололтой.


Судлаачдын тэмдэглэснээр шүдний цоорол нь мал маллан түүний ашиг шимийг хүртэн аж төрдөг хүн амыг бодвол суурьшмал соёл иргэншилтэй, газар тариалан эрхэлдэг хүн амд илүү их тохиолддог, харин шүдний чулуужилт нь суурьшмал иргэдийг бодвол нүүдэлчдэд илүү тохиолддог байна. Үүнээс үзэхэд, **Баянбулагийн сууринд амьдралын хэв маяг, эрхэлдэг аж ахуй, хэрэглэж байсан хоол хүнсээрээ тухайн үеийн нүүдэлчдээс эрс ялгаатай, газар тариалан эрхэлдэг юм уу аль эсвэл суурин газраас ирсэн хүн ам оршин сууж байсан бололтой.**

НОМ ЗҮЙ

1. З.Батсайхан. Хүннү. УБ., 2002
2. Б.Наран. Баруун Монголын эртний нүүдэлчдийн өвчлөлт. УБ., 2003
3. Д.Цэвээндорж, З.Батсайхан, Ц.Төрбат. Сүннүгийн хот суурины судалгаа. //ШУА-ийн мэдээ. УБ., 1994.,
4. Х.Пэрлээ. Монгол ард улсын эрт дундад үеийн хот суурины товчоон. УБ., 1961
5. Д.Цэвээндорж, Д.Баяр, У.Эрдэнэбат. Монголын эртний хот суурины судалгаа. -// Монгол улсын шинжлэх ухаан. Боть 32. УБ., 2007
6. Д.Эрдэнэбаатар, Т.Идэрхангай, Э.Мижиддорж, А.В. Харинский, А.М.Коростелев, Д.Е.Кичигин, С.С.Матренин, И.Ю.Гребнников, А.В.Варенов, А.А.Ковалев. Монгол-Оросын хамтарсан “Төв Азийн археологийн шинжилгээ” археологийн хээрийн шинжилгээний ангийн Хөвсгөл аймгийн Ханх сум, Өмнөговь аймгийн Номгон сумдын нутагт ажилласан археологийн судалгааны ажлын 2009 оны тайлан. УБ-ИС-ийн НУФ-ийн Археологийн тэнхимийн ГБС. УБ., 2009.
7. Maschner D.G., Christoher Chippindale. Handbook Archaeological methods. Volume II.

ХАВСРАЛТ 1.

Олдворын ерөнхий байдал



ХАВСРАЛТ 1.

Олдворын гол хэсэг

